



**ТАВАНТОЛГОЙ ХК**  
**ӨМНӨГОВЬ АЙМАГ**  
**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 1/25

Өмнөговь аймаг, Цогтцэций сум

Тавантолгой ХК-ийн Экспортын  
нүүрсний нээлттэй дуудлага  
худалдааны журмыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 450 дугаар тогтоол, “Тавантолгой” ХК-ийн “Компанийн үйл ажиллагааны журам”-ын 1 дүгээр бүлэг, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 114 дүгээр зүйлийн 114.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Тавантолгой” ХК-ийн “Экспортод гаргах нүүрсний нээлттэй дуудлага худалдааны журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөхийг дурдсугай.
3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж, бэлтгэл ажлыг хангахыг Борлуулалт маркетинг, тээврийн газар /Ч.Гүнждагва/-д даалгасугай.

ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ  
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ



П.САЙНЗОРИГ

“Тавантолгой” Хувьцаат компанийн  
гүйцэтгэх захирлын 2023 оны 02 дугаар  
сарын 02-ны өдрийн 1/025 тушаалын  
хавсралт



## ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар “Тавантолгой” ХК-ийн экспортод гаргах нүүрсийг Монгол Улсын Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу нээлттэйгээр үнэ хаялцуулах замаар буюу дуудлага худалдааны хэлбэрээр худалдан авагчийг сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулж хамтран ажиллахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Үнэ хаялцуулах/цаашид Дуудлага худалдаа гэнэ/ ажиллагааг зах зээлийн нөхцөл байдал, олборлолт, борлуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан нээлттэй, шударга, сонирхогчдын оролцоо, тэгш байдлыг хангаж, мэдээллийг ил тод байдлаар хүргэх зарчмыг хангаж явуулна.

### Хоёр.Ерөнхий нөхцөл, шаардлага

2.1. Дуудлага худалдааг зохион байгуулагч нь Тавантолгой ХК-иас томилогдсон ажлын хэсэг/цаашид комисс гэх/ байна.

2.2. Дуудлага худалдаагаар хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд нь ялагч болно.

2.3. Дуудлага худалдаанд нэг ч этгээд оролцоогүй бол дуудлага худалдаа явагдаагүй гэж үзнэ.

2.4. Дуудлага худалдааг танхимын зохион байгуулалттайгаар нээлттэй явуулна.

2.5. Компани дуудлага худалдаагаар худалдаалах нүүрсний багц, үнэ чанар, зохион байгуулах газрын талаарх мэдээллийг урьдчилан нийтэд нээлттэй мэдээлнэ.

2.6. Комисс нь дуудлага худалдааны зарыг дуудлага худалдаа зохион байгуулахаас ажлын 5 өдрийн өмнө нийтэд мэдээлнэ.

2.7. Дуудлага худалдааны зард дараах мэдээллийг тусгана. Үүнд:

2.7.1. Дуудлага зохион байгуулах огноо;

2.7.2. Нүүрсний багцын тоо, чанар, стандарт;

- 2.7.3. Нүүрс нийлүүлэх цэг;
- 2.7.4. Дэнчингийн хэмжээ болон дэнчин байршуулах банк нэр, дансны дугаар;
- 2.7.5. Дуудах доод үнэ, валютын төрөл;
- 2.7.6. Дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн;
- 2.7.7. Мэдээлэл авах хаяг, утасны дугаар.

2.8. Дуудлага худалдааны зарыг нийтэд илт тод байдлаар Тавантолгой ХК-ийн албан ёсны цахим хуудас [www.tavantolgoi.mn](http://www.tavantolgoi.mn)-д нийтэлнэ.

2.9. Дуудлага худалдааг багц тус бүрээр явуулах бөгөөд нэг оролцогч хэдэн ч багцын дуудлага худалдаанд оролцож болно.

### **Гурав. Дуудлага худалдаанд оролцогчийг бүртгэх**

3.1. Дуудлага худалдааг зохион байгуулах комисс нь дуудлага худалдаанд оролцогчдын бүртгэлийн хүснэгтийг урьдчилан бэлтгэсэн байна.

3.2. Дуудлага худалдаанд оролцох оролцогчдын нэрс болон дэнчин төлсөн баримтыг урьдчилан цахим шуудангаар эсхүл бичгээр авна.

3.3. Дуудлага худалдаанд оролцогч нь дуудлага худалдаа болох өдрөөс 1-ээс доошгүй хоногийн өмнө дуудлага худалдаанд оролцох тухай хүсэлтийг дараах бичиг баримтын хамт ирүүлнэ. Үүнд:

- 3.3.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
  - 3.3.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх санхүүгийн чадамжтайг нотолсон баримт;
  - 3.3.3. Компанитай өмнө нь байгуулсан гэрээний үүргийн зөрчилгүй байх;
  - 3.3.4. Монгол Улсад бүртгэлтэй төлөөлөгчийн газрын мэдээлэл, итгэмжлэл
  - 3.3.5. Бусад шаардлагатай гэж үзсэн баримтыг ирүүлэх.
- 3.4. Комисс нь шаардлагатай бол дуудлага худалдааг цуцалж болох бөгөөд энэ тухай дуудлага худалдаа болох өдрөөс 1-аас доошгүй хоногийн өмнө нийтэд зарлана.

### **Дөрөв. Дэнчин**

4.1 Дуудлага худалдаагаар худалдаалах 50 000 тонн багцын дэнчин 10 000 ам доллар байна.

4.2 Дуудлага худалдаагаар худалдаалах 25 000 тонн багцын дэнчин 5000 ам доллар байна.

4.3 Дуудлага худалдаанд оролцогч нь зард заасан хэмжээгээр дэнчинг байршуулсан эсэхийг баталгаажуулсны үндсэн дээр дуудлага худалдаанд оролцох эрхтэй гэж үзнэ.

4.4 Ялагчаас бусад оролцогчийн дэнчинг дуудлага худалдаа болсноос хойш ажлын 3 өдрийн дотор буцаан олгоно.

4.5 Дэнчинг буцаан олгохдоо банкны шимтгэл, суутгалыг дуудлага худалаанд оролцогч хариуцна.

### **Тав.Дуудлага худалдаа зохион байгуулагчийн эрх, үүрэг**

5.1. Комисс нь дуудлага худалдаанд оролцогч болон олон нийтэд үнэн зөв мэдээллийг шуурхай хүргэнэ.

5.2. Дуудлага худалдааг зохион байгуулах байр, танхим,техник хэрэгслийг бэлтгэж оролцогчдод саадгүйгээр үйл ажиллагааг зохион байгуулна.

5.3. Компани нь” Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал MNS 6457:2022” стандартад заасан төрөл, ангилал чанарын үзүүлэлттэй нүүрсийг дуудлага худалдаагаар борлуулна.

5.4. Комисс нь худалдаалах нүүрсний баримт бичгийн бүрдүүлбэрийг ханган мэдээллийг дуудлага худалдаанд оролцогч бүрт өгнө. Үүнд:

5.4.1. Дуудлага худалдаагаар худалдаалах нүүрсний багцын тоо, тухайн багцад хамаарах нүүрсний төрөл, ангилал чанарын үзүүлэлт;

5.4.2. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийн хуулбар;

5.4.3. Дуудах доод үнэ, валютын төрөл

5.4.4. Үнэ өсгөх хэмжээ

5.5. Дуудлага худалдаа зохион байгуулж байгаа үйл явцыг дуу дүрсний бичлэгээр баталгаажуулж, хадгална.

### **Зургаа.Дуудлага худалдаанд оролцогчийн эрх, үүрэг**

6.1. Дуудлага худалдаанд оролцох хүсэлтэй этгээд нь хуулийн этгээд байх бөгөөд зуучлагчгүйгээр дуудлага худалдаанд биечлэн оролцоно.

6.2. Дуудлага худалдаагаар худалдаалах нүүрсний багц, үнэ, чанартай холбоотой мэдээллийг шаардаж авах эрхтэй.

6.3. Дуудлага худалдаанд оролцогч нь хэд хэдэн багцын дуудлага худалдаанд оролцох эрхтэй.

6.4. Дуудлага худалдааны дэг журмыг сахих үүрэгтэй.

6.5. Дуудлага худалдааны явцад бусдыг хүндэтгэх, тэгш шударга өрсөлдөнө.

### **Долоо.Дуудлага худалдаа явуулах аргачлал, дараалал**

7.1. Дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээд энэ тухай хүсэлтээ үнэн зөв гаргаж, дэнчин болон холбогдох баримтаа хавсарган дуудлага худалдааны комисст хүлээлгэн өгнө.

7.2. Дуудлага худалдаанд оролцох нэг ч хүсэлт ирээгүй тохиолдолд дуудлага худалдааны комисс дуудлага худалдаа явагдахгүй болсон тухай нийтэд мэдэгдэх бөгөөд дахин дуудлага худалдаа явагдах талаар мэдээлнэ.

7.3. Комисс нь дуудлага худалдаанд оролцох хүсэлт гаргагчдын материалын бүрдлийг шалган авч оролцогчдын жагсаалтыг гарган дугаар олгоно.

7.4. Хөтлөгч дуудлага худалдааны удирдамжтай танилцсан байх ёстойг оролцогчдод анхааруулна.

7.5. Хөтлөгч нүүрсний багц тоо хэмжээ, чанар, үнийн саналын тухай товч танилцуулж, дуудлага худалдааны үнийг өсгөн хэлэх доод хэмжээг зарласнаар дуудлага худалдаа эхэлнэ.

7.6. Дуудлага худалдаанд оролцогчид үнийн саналаа ээлж дараалан өсгөж хэлнэ. Дуудлага худалдааны ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна.

7.7. Дуудлага худалдааг дараах дарааллаар явуулна:

7.7.1. Дуудлага худалдаанд оролцогчдыг байраа эзлэхийг гурав дахь удаагаа урихад бүртгүүлэх оролцогч гарч ирээгүй бол түүнийг дуудлага худалдаанд оролцохоос татгалзсанд тооцож, энэ тухай дуудлага худалдааны тэмдэглэлд тусгана.

7.7.2. Оролцогчдыг бүртгэж дууссаны дараа комиссын дарга дуудлага худалдаа албан ёсоор эхэлснийг зарлана.

7.7.3. Дуудлага худалдааг эхлүүлэхдээ бага хэмжээтэй багцаас эхэлж дуудлага худалдааг явуулна.

7.7.4. Оролцогч үнийн санал хэлэхэд хөтлөгч тэр үнийн саналыг гурван удаа давтаж хэлэх ба 1 минутын хугацаанд бусад оролцогчид түүнээс дээш үнийн санал хэлээгүй тохиолдолд хөтлөгч "буулаа" гэж хэлээд "нэг", "хоёр", "гурав" гэж тоолсны дараа тухайн багц борлуулагдсаныг зарлаж хаасныг мэдэгдэнэ.

7.7.5. Дуудлага худалдааг гэрээ байгуулах эрх олж авах нөхцөлтэйгөөр явуулна.

7.7.6. Дуудлага худалдааны тэмдэглэл нь гэрээ байгуулах урьдчилсан нөхцөл болно.

7.8. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах

7.8.1. Дуудлага худалдааны ялагчид гэрээ байгуулах эрх олгох бөгөөд ялагч нь гэрээ байгуулах баталгааг/урьдчилгаа төлбөр төлнө/ төлнө.

7.8.2. Ялагч нь дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор Нүүрс худалдах худалдан авах тухай гэрээ байгуулна.

7.8.3. Тавантолгой ХК болон худалдан авагчийн хоорондын гэрээнд дуудлага худалдааны ялагчийн зарласан үнийг заах бөгөөд энэхүү үнийг талууд өөрчлөх эрхгүй.

7.8.4. Талуудын аль нэг нь гэрээ байгуулахаас зайлсхийвэл нөгөө тал нь гэрээ байгуулсанд тооцож үүргийн гүйцэтгэлийг хангуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

7.8.5. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулахтай холбогдсон харилцааг “Тавантолгой ХК-ийн нүүрс борлуулах журам”-ын дагуу зохицуулна.

7.9. Ялагч тогтоосон хугацаанд гэрээ байгуулаагүй бол дуудлага худалдаанд тухайн багцад дараагийн үнэ дуудсан оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгох эсэхийг комисс шийдвэрлэнэ.

7.10. Дуудлага худалдааны явцад гарсан энэхүү журмаар зохицуулаагүй аливаа асуудал, маргааныг комисс тухай бүр шийдвэрлэх бөгөөд комиссын шийдвэр эцсийн байна.